



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ТУШААЛААР ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

/2017 оны жилийн эцсийн байдлаар/

2017.12.27

ЗТХЯ-ны ТНБД-ын 170 тушаалын 282 үүрэг даалгаврыг хяналтад авч, хэрэгжилтийн явцад 2017 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналтад байгаа нийт үүрэг даалгаврын 213 нь биелсэн, 38 заалт 70%, 9 заалт 30%, 1 заалт хэрэгжээгүй буюу биелэлтээ ирүүлээгүй, 10 заалтын хэрэгжүүлэх хугацаа болоогүй, 11 заалт тушаалаар хүчингүй болсон, нийт **92.8** хувийн биелэлттэй байна.

ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан хэрэгжүүлэх газар тус бүрээр нь гаргавал дараах байдалтай байна. Үүнд:

№	Газрын нэрс	Нийт заалт	Үүнээс /хувиар/					Хүчингүй болсон	Биелэлт хувь
			100	70	30	Хэрэгжээгүй, биелэлт ирүүлээгүй	Хугацаа болоогүй		
1	БТГ	84	63	12	4	-	3	2	91.9
2	ТЗУГ	59	39	9	2	-	3	6	91.8
3	ХШУДАГ	96	78	14	2	-	-	2	94,0
4	АЗБХЗГ	77	57	14	1	-	5	-	93,2
5	АТБХЗГ	38	24	12	-	-	-	2	90.0
6	ТЗДТБХЗГ	51	43	8	-	-	-	-	95.3
7	АТБХЗХ	19	16	3	-	-	-	-	95.3
8	ИНЕГ	4	2	1	-	-	-	1	90.0
9	ЗТХТ	5	2	2	1	-	-	-	74.0
10	АТҮТ	4	2	1	1	-	-	-	75.0
11	ГТХЗНТ	1	1	-	-	-	-	-	100.0
12	МИАТ	1	-	1	-	-	-	-	70.0
13	УБТЗ	12	10	1	-	1	-	-	89.2
14	МТЗ	2	-	2	-	-	-	-	70.0
15	Далайн захиргаа	2	-	2	-	-	-	-	70.0
16	төслийн нэгж	9	6	2	1	-	-	-	85.6
17	Нийслэлийн тээврийн газар	2	-	-	1	1	-	-	15.0
	Нийт	282	213	38	9	1	10	11	92.8



ТНБД-ын 2012 оны 1, 2013 оны 6, 2014 оны 3, 2015 оны 13, 2016 оны 41, 2017 оны 106 тушаал хяналтад байгаагаас 11 нь дүрэм, журам баталсан тушаал, 4 нь дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөө баталсан, 11 нь байнгын ажиллагаатай ажлын хэсэг, комисс томилсон, 127 нь нэг удаагийн үүрэг даалгавар хэрэгжүүлэх ажлын хэсэг, комисс, үнэлгээний хороо байгуулсан тушаал байна.

Хяналтад байгаа 170 тушаалын 282 үүрэг даалгавраас хэрэгжсэн, хэрэгжилт тогтмолжсон, хүчингүй болсон болон хэрэгжих боломжгүй болсон 136 тушаалын 220 заалтыг хяналтаас хаслаа.

Хэрэгжихгүй удаашралтай байгаа 2013-2016 оны тушаалуудын 121 заалтыг яаралтай хэрэгжүүлэх талаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласны үр дүнд 2017 оны жилийн эцсийн байдлаар 97 нь хэрэгжсэн, хэрэгжилт тогтмолжсон болон хүчингүй болсон тул хяналтаас хасагдсан. Үлдсэн 24 заалтыг ойрын хугацаанд хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнах шаардлагатай байна.

Ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүд ажлаас чөлөөлөгдсөнөөс тухайн ажлын хэсгийн ажил удааширч хугацаа алдах тохиолдол гарч байгаа тул асуудал хариуцсан мэргэжилтэн чөлөөлөгдсөн тохиолдолд тухай бүр тушаалд нэмэлт өөрчлөлт оруулж байх, байнгын ажиллагаатай ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүдийг албан тушаалын нэрээр томилж байх нь зүйтэй байна.

Тушаалын биелэлтийг тайлагнах үед харьяа байгууллага, яамны газар, хэлтсийн мэргэжилтнүүд өөрт холбоотой тушаал шийдвэр гарсныг мэдээгүй гэх гомдол гарсан хэвээр байна. Тухайлбал ИНЕГ, АТҮТ ТӨҮГ, ЗТХТ ТӨҮГ, Далайн захиргаа, УБТЗ ХНН-аас зарим тушаал, шийдвэрүүд албан ёсоор ирээгүй тул эх хувийг ирүүлэхийг хүсч, ХШҮДАГ-аас эдгээр байгууллагуудад хүргүүлсэн.

ЗТЯ-ны гэрээ байгуулах ажиллагааг зохион байгуулах журам, Зам, тээврийн салбарын эрх зүйн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх журам, Яамны вэб сайтын үйл ажиллагааг зохицуулах журам, Зам, тээврийн салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл баталсан 2013, 2014, 2015 оны тушаалуудыг шинэчлэн Зам, тээврийн хөгжлийн яамны журам, зөвлөл болгох шаардлагатай байна.

Хяналтад байгаа 282 үүрэг даалгавраас хэрэгжилт удааширч байгаа дараах үүрэг, даалгаврыг ойрын хугацаанд хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнан хяналтаас хасуулах шаардлагатай байна. Хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудыг хавсаргав. /Хавсралт 1/

Санал, зөвлөмж:

1. Газар, хэлтсүүд удаашралтай хэрэгжиж байгаа (ялангуяа 2012-2016 оны) үүрэг даалгаврыг 2018 оны I улиралд багтаан хэрэгжүүлж дуусгах;
2. Ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүд ажлаас чөлөөлөгдсөн тухай бүр тушаалд нэмэлт өөрчлөлт оруулж байх, байнгын ажиллагаатай ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүдийг албан тушаалын нэрээр томилж байх;
3. Тушаал боловсруулан гаргасан ажилтан “Зам, тээврийн хөгжлийн яамны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны журам”-ын дагуу тухайн тушаалаар үүрэг өгөгдсөн байгууллага, албан тушаалтанд тушаалын хувийг албан ёсоор хүргүүлж хэвших, ТЗУГ-аас хяналт тавьж ажиллах;
4. “Зам, тээврийн салбарын эрх зүйн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх журам”-ыг судлан хэрэгжүүлэх боломжгүй бол шинэчлэх, хүчингүй болгох арга хэмжээ авах;



5. Зам, тээврийн яамны үед баталсан дотоод журам, байнгын ажиллагаатай ажлын хэсэг, зөвлөлийг Зам, тээврийн хөгжлийн яамны журам, зөвлөл болгон шинэчлэх,
6. Тушаалд тухайн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх хугацааг заавал тусгаж байх;

Танилцсан:

Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ

Төрийн захиргааны удирдлагын газрын даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Махбал

Бодлого төлөвлөлтийн газрын
дарга Р.Мэргэн

Авто замын бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга Д.Доржханд

Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга С.Батболд

Төмөр зам, далайн тээврийн бодлогын
хэрэгжилтийг зохицуулах
газрын дарга Б.Артур

Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах хэлтсийн дарга С.Мөнхнасан

Хянасан:

ХШҮДАГ-ын даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч Т.Гомбосүрэн

Боловсруулсан:

ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн Д.Баярмаа



ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгавраас хэрэгжилт удаашралтай байгаа заалтууд

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Хэрэгжүүлэх газар, хэлтэс, хугацаа	Хэрэгжүүлэх заалт	Биелэлт	Хувь
1.	Ажил үүрэг хариуцуулах тухай 2012.09.25 №34	ТЗУГ 2012.12.31	1.Засгийн газрын бүтцийн өөрчлөлтөөр татан буугдсан харьяа агентлагуудын ашиглаж байсан баримт бичгүүд болон архивын материалуудыг Үндэсний төв архивт 2012.12.01-ний өдрийн дотор албан ёсоор хүлээлгэн өгөхийг татан буугдсан АЗГ-ын архив, бичиг хэргийн ажилтан Ж.Тунгалаг, АТГ-ын бичиг хэргийн ажилтан С.Нансалмаа, ЗТЯны бичээч-операторчин З.Хандсүрэн нарт тус тус үүрэг болгосугай.	Авто тээврийн газрын байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл 2002-2012 оны 59 хадгаламжийн нэгж, устгах хэргийн акт 2002-2009 оны 8 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 1985-2012 оны 39 хадгаламжийн нэгж түр хадгалах хадгаламжийн нэгж 2005-2012 оны 693 хадгаламжийн нэгжийг Үндэсний төв архивын БНШАЗК-ын 2015 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар хуралдаж батлуулсан. Архивын хадгаламжийн нэгжийг хүлээлгэн өгөх шийдвэрийг УТА-аас хүлээж байна. Архивын газраар баталгаажуулсан бүртгэлээ ТНБД-аар баталгаажуулахаар бэлтгэж байна. АЗГ-ын 2009-2012 оны архивын байнга 379, түр 810, устгах 27, 70 жил 23 боть хадгаламжийн нэгжийг бүртгэлийг хийж, УТА-ын газрын хурлаар оруулахад бэлэн болоод байна. ТЗГ-ын байнга, түр, устгах гэсэн төрлөөр ангилан хадгаламжийн нэгжийн бүртгэлийг хийж дуусаад Үндэсний төв архивын газарт бүртгэлийг өгсөн. БНШАЗК-ын хурал болоогүй хүлээгдэж байна.	70
2.	Ажлын хэсэг томилон ажиллуулах тухай 2013.03.11 №89	ТЗУГ 2013.03.20	2.Татан буугдсан Төмөр замын газрын архивын баримтыг цэгцлэх ажлыг 2013.03.20-ны дотор хийж гүйцэтгэн байгууллагын архивын ажлын үндсэн зааврын дагуу бүртгэл үйлдэж, YAГ-ын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэх батлуулахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай. Нбд –З.Хандсүрэн	ТЗГ-ын байнга, түр, устгах гэсэн төрлөөр ангилан хадгаламжийн нэгжийн бүртгэлийг хийж дуусаад Үндэсний төв архивын газарт бүртгэлийг өгсөн. БНШАЗК-ын хурал болоогүй хүлээгдэж байна.	70
3.	Журам батлах тухай 2013.07.24 №260	ТЗУГ	2.Энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг ТЗУГ /П.Билгүүн/-т даалгасугай. /Зам, тээврийн салбарын эрх зүйн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх журам/	Зам, тээврийн салбарын эрх зүйн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх журмын дагуу Захиргааны хэм хэмжээ тогтоосон, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй шийдвэрүүдийг 2017 оны байдлаар "Эйбл" программын олон нийт хэсэгт "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр" гэсэн цэс шинээр үүсгэн байршуулж албан хаагчдад танилцуулан ажиллаж байна. Хууль зүй дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд:	30



				Яамнаас батлан гаргасан зам, тээврийн салбарт нийт 67 улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр хүчин төгөлдөр актын жагсаалтыг цахим санд олон нийтэд танилцуулахаар байршуулж ажиллав. Үүнээс: - Автотээврийн салбарт 19 - Төмөр зам, далайн тээврийн салбарт 23 - Авто замын салбарт 10 - Иргэний нисэхийн салбарт 14 - Нийтийн аж ахуйн салбарт 1	
4.	Шалгалтын комисс томилох тухай 2015.03.19 №84	УБТЗ	2.Шалгалтыг холбогдох дүрэм, журмын хүрээнд авч, дүнг Төмөр замын салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох зөвлөлд танилцуулахыг шалгалтын комиссын дарга /Г.Вандандагва/-д даалгасугай. НБд-Л.Ганчимэг	Биелэлт ирүүлээгүй.	0
5.	Автотээврийн салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай 2015.07.10 №255	БТГ	3. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төвд барьж буй Зорчигч тээврийн автовокзалын барилгыг үргэлжлүүлэн барих боломжгүй байдал үүссэн тул дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг холбогдох газруудад даалгасугай. 3.1. Барилгын гүйцэтгэгч "Бридж констракшн" ХХК-тай тооцоо нийлэх, гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй тус компанийг холбогдох хууль тогтоомжийн дагуу СЯ-д хандаж хар жагсаалтад оруулахыг СБТХАГ /С.Адъяасүрэн/- т	Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдаж буй зорчигч тээврийн автовокзалын барилгын ажлыг одоогийн байдлаар хүлээлцэх ажлыг эрчимжүүлэх үүднээс 01/4533 дугаар албан бичгийг "АТҮТ" ТӨҮГ-т 2015-10-13-ны өдөр хүргүүлсэн. Барилгыг одоогоор хүлээн авч гэрээгээ дуусгавар болгон тооцоо нийлээгүй байна. "АТҮТ" ТӨҮГ-ын захирлын 2015 оны А/253 дугаар тушаалаар Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдаж буй зорчигч тээврийн автовокзалын барилгыг газар дээр нь одоогийн байгаа гүйцэтгэлээр хүлээлцэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан байна. Уг ажлын хэсэг 2015.11.19-22-ны өдрүүдэд тус суманд очиж ажиллан, уг барилгыг одоогийн гүйцэтгэлээр хүлээн авсан тухай актыг 1/2033 дугаар албан бичгээр 2015.11.27-ны өдөр тус яаманд ирүүлсэн. Автовокзалын барилгыг концессын гэрээгээр үргэлжлүүлэн барих гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний төслийг боловсруулж, "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" Засгийн газрын 2016 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан. Концессын асуудлыг Үндэсний хөгжлийн газар хариуцаж байгаа бөгөөд төлбөр тооцоотой холбоотой асуудал гаргаагүй тул хяналтаас хасуулах саналтай.	30
		АТБХЗГ АТҮТ	5. "Контракс Еад" ХХК гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй, гэрээнд тусгасан зарим заалтууд хэрэгжээгүй, нийлүүлэхээр тохирсон тоног төхөөрөмжийн үнэ өссөн зэрэг	ТНБД-ын 2017.05.12-ны өдрийн 139 дүгээр тушаалаар байгуулсан Ажлын хэсэг ажиллаж "Тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил"-ын 45/А тоот	70



			зөрчил илэрсэн, гэрээт ажлаа хугацаандаа хэрэгжүүлээгүй тул гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцалж, гүйцэтгэсэн ажлыг одоогийн байдлаар хүлээн авч тооцоо нийлэхийг СБТХАГ /С.Адъяасүрэн/, АЗТБХЗГ /Д.Доржханд/, АТҮТ /Н.Пунцаг/-т тус тус даалгасугай.	гэрээний хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүд хэвийн ажиллагаатай эсэхийг шалгах тооллого хийж, тайланг Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Э.Идэрцогд 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 03/2892 тоот албан бичгээр хүргүүлсэн.	
6.	Ажлын хэсэг байгуулах тухай 2015.07.22 №264	АТБХЗГ 2015.08.20	2.Хуулийн хүрээнд ажлыг шуурхай зохион байгуулж, Ажил хүлээлцсэн актыг үйлдэн 2015.08.20-ны дотор яамны удирдлагад танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Я.Мөнхжаргал/-д даалгасугай. /400 автобусыг дизель-хийн түлшний хосолмол хэрэглээнд шилжүүлэх, тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах ажлын гэрээг дүгнэж, дуусгавар болгох ажлын хэсэг/ нбд-Д.Ариунтуяа	Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 255 дугаар тушаалаар их багтаамжийн 400 автобусыг хийн хосолмол хэрэглээнд шилжүүлэх ажил, хий нийлүүлэх, түгээх станц барих ажил хийгээгүйгээс цаашид хэрэгжих боломжгүй талаар Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороонд танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулахыг Техник, технологи, нормативын хэлтэс /хуучнаар/-т үүрэг болгосон тул АЗТБХЗГ-ын /хуучнаар/ 2016 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотоод албан бичгээр уг төслийн хүрээнд нийтийн зорчигч тээврийн их багтаамжийн 400 автобусанд дизель-хийн түлшний хосолмол хэрэглээнд шилжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн ажлын талаарх танилцуулгыг хүргүүлсэн. АТБХЗГ-ын дарга дээр 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр асуудлыг гүйцэтгэгчийн төлөөлөл болон яамны холбогдох ажилтнуудыг байлцуулан хэлэлцэж гүйцэтгэсэн ажлын бүрэн танилцуулга хийх, танилцуулгын дараа дүгнэлт гаргаж, гэрээг дуусвар болгох холбогдох шийдвэр гаргуулахаар тохиролцов. "Тур телком" ХХК-иас Зам, тээврийн яам/хуучнаар/-тай байгуулсан ЦАС-УБ-04/2011 гэрээний хэрэгжилтийг дүгнэн дуусгавар болгох талаар 2017 оны 17/08-389 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг судлан, Зам, тээврийн хөгжлийн сайдаас өгсөн зөвлөмжийн дагуу хувийн хэвшлийн их багтаамжийн 150 автобусанд тоног төхөөрөмжийг суурилуулан дизель-хийн хосолмол хэрэглээнд шилжүүлэх арга хэмжээ авах тухай 2017 оны 01/4205 тоот албан бичгийг нийслэлийн Засаг даргад хүргүүлсэн. Үндэсний аудитын газраас БОАЖ-ын яаманд хүргүүлсэн 2017 оны 01/73 тоот "Зөрчил арилгуулах тухай" албан бичигт ЦАС-УБ-04/2011 гэрээний хэрэгжилт 62.5%-ийн гүйцэтгэлтэй байгааг дурдахын сацуу гэрээг дүгнэх, урьдчилж төлсөн зардлын үлдэгдлийн тооцоог нийлэх, бүртгэлийн асуудлыг шийдвэрлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхийг үүрэг болгосон. Тус үүргийн дагуу БОАЖЯ-ы сайдын 2017 оны А/319 дүгээр тушаалаар ЦАС-УБ-04/2011 гэрээний хэрэгжилтийг дүгнэх, урьдчилж төлсөн зардлын үлдэгдлийн тооцоог нийлэх, бүртгэлийн асуудлыг шийдвэрлэх Ажлын хэсэг байгуулагдсан	70



				ажиллаж байна. Энэхүү Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус яамны АТБХЗГ-ын мэргэжилтэн З.Чүнсэрээ ажиллаж байна.	
7.	Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2015.08.10 №296	ТЗУГ БТГ	1. ЗТБХЗЯ /хуучин нэрээр/, нийслэлийн Өмчийн харилцааны газар, нийслэлийн Нийтийн тээврийн газар /хуучин нэрээр/, автобус хүлээн авсан нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж буй аан-үүдийн хамтран байгуулсан 2009 оны "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн автобусыг зээлээр эзэмшүүлэх гэрээ"-ний биелэлт хэрэгжихгүй байгаатай холбогдуулан улсын төсвийн хөрөнгийн эргэн төвлөрүүлэх шаардлагатай төлбөрийг буцааж төвлөрүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргахыг ТЗУХЭЗГ /Д.Занданбат/, СЭЗХ /З.Цэрэнчимэг/-т үүрэг болгосугай.	ЗТС, Нийслэлийн засаг дарга нарын хамтарсан 2014.08.01-ны өдрийн 189/А/661 дугаар тушаал, захирамжаар байгуулагдсан "Ажлын хэсэг"-ийн дүгнэлтээр 2009 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 400 автобусны үлдэгдэл төлбөрийг буцаан төвлөрүүлэх асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах ажлын хүрээнд Төрийн өмчийн хороо, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийтийн тээврийн газраас уг асуудалд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хамтран оролцох албан хаагчдын нэр ирүүлэх талаар 2015.10.12-ны өдрийн 01/4479 тоот албан бичгийг тус тус хүргүүлэв. Нийслэлийн өмчийн харилцааны газраас 2016.02.23-ны өдрийн 4/1021 тоот, Нийтийн тээврийн газраас 2016.02.01-ний өдрийн 1/205 тоот албан бичгээр холбогдох албан тушаалтнуудын нэрсийг ирүүлсэн байна. Тус яамнаас 2016 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Нийслэлийн өмчийн харилцааны газар болон Нийтийн тээврийн газраас нэр ирүүлсэн нэр бүхий албан хаагч /Нийслэлийн өмчийн харилцааны газрын Өмчийн хөдөлгөөн хувьчлалын хэлтсийн дарга Д.Итгэл, хуулийн хэлтсийн мэргэжилтэн Ё.Энхээ, Нийслэлийн тээврийн хуульч Э.Энхтөр/-тай хуралдаж, 400 автобусны үнийг нэхэмжлэх асуудлаар шүүхэд хандахаар холбогдох материалыг судлан санал солилцож, Нийслэлийн тээврийн газрын мэргэжилтэн Э.Энхтөрөөс нэмэлт материал болон зарим нэг асуудлыг тодруулсанаар эргэж хуралдахаар болсон. Нийслэлийн өмчийн харилцааны газарт бүтцийн өөрчлөлт болж, холбогдох албан тушаалтнууд өөрчлөгдөж байх тул эргэж хариу мэдэгдэхээр болсон. Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас 400 автобустай холбоотой материалыг ирүүлээгүй тул шүүхэд нэхэмжлэл гаргаагүй болно. Иймд АТБХЗГ-аас биелэлт авах.	30
		БТГ АТБХЗГ	2. Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн сангийн эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх үүднээс ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ЗГ-ын шийдвэрийн төсөл боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхийг СБТХАГ	Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн сангийн эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх үүднээс ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ЗГ-ын шийдвэрийн төслийг боловсруулаад байна. Засгийн газраас аливаа мөнгө төгрөгтэй холбоотой асуудлыг ойрын хугацаанд Засгийн газрын хуралдаанаар оруулахгүй байх чиглэл өгсөн тул хүлээгдэж байна.	30



			/Д.Адъяасүрэн/, АТХ /Я.Мөнхжаргал/-т үүрэг болгосугай.		
		Нийслэлийн тээврийн газар	3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан их багтаамжийн 400 автобусны төлбөрийн тооцоог нэгтгэн гаргаж тус яаманд ирүүлэх, эдгээр автобусыг зохих хууль тогтоомжийн дагуу Нийслэлийн өмчид шилжүүлэн бүртгүүлэхийг Нийслэлийн тээврийн газар /Ч.Энхбат/-т үүрэг болгосугай.	Тушаалыг 2015.08.13-ны өдрийн 04/3555 тоот албан бичгээр Нийслэлийн тээврийн газарт хүргүүлсэн. Нийслэлийн тээврийн газраас автобусны төлбөр тооцооны талаарх мэдээллийг яаманд ирүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх заалт "Улсын Их Хурал төрийн өмчийн талаар дараахь бүрэн эрхтэй" -ын 4 дэх хэсэгт "Төрийн өмчийг барьцаалах, орон нутгийн өмчид шилжүүлэх тухай шийдвэр гаргах;" гэж заасан байгаа тул Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан их багтаамжийн 400 автобусыг нийслэлийн өмчид шилжүүлэн бүртгэхийн тулд УИХ-ын шийдвэр гаргуулах шаардлагатай гэж Нийслэлийн тээврийн газар болон ажлын хэсгээс үзсэн.	30
8.	Ажлын хэсэг байгуулах тухай 2015.09.28 №368	БТГ	2. Сонгон шалгаруулалтыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу зохион байгуулахыг Ажлын хэсгийн дарга /З.Цэрэнчимэг/-д, холбогдох материалыг архивын нэг болгон бүрдүүлж архивд хүлээлгэн өгөхийг Ажлын хэсгийн нбд /Ч.Баясгалан/-д тус тус даалгасугай. /"Авто зам, гүүрийн бэлэн байдлын судалгаа хийх зориулалт бүхий тусгай үйлдвэрт үйлдвэрлэсэн, бүрэн тоноглогдсон автомашин" нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул шууд гэрээ байгуулах ажлын хэсэг/	Ажлын хэсэг хуралдаж, уг ажлын санхүүжилтийн эх үүсвэр байгаа эсэх талаар тодруулахаар албан бичгийг СЯ-д 2015.10.05-ны өдрийн 03/4313 тоот албан бичгээр хүргүүлсэн бөгөөд СЯ-ны зүгээс 2015.10.15-ны өдрийн 10-2/6066 албан бичгээр "Монгол Улсын Засгийн газар, Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтын сан хооронд байгуулсан Дархан-Эрдэнэт чиглэлийн авто замын төслийн зээлийн хугацаа дуусгавар болж, зээлийн үлдэгдлийг ашиглах боломжгүй болсон" гэсэн хариуг тус яаманд ирүүлсэн бөгөөд уг асуудлыг ТНБД-д танилцуулсан. Мөн тус яамны зүгээс 2015.12.10-ны өдрийн 03/5586 албан бичгээр СЯ-д хандаж, дээрх төслийн зээлийн хугацааг 2016.12.01-ний өдрийг хүртэл сунгаж өгөх талаар хүсэлтийг хүргүүлж, Зээлийн гэрээг 2016 оны 07 сарын 31-ний өдрийг хүртэл сунгуулсан. 2016 оны 05-р сарын 11-ний өдрийн 02/2005 дугаар албан бичгээр тус зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл 368,357.0 кувейт динарыг ашиглах хүсэлтийг Кувейтын санд уламжилж өгөхийг СЯ-наас хүссэн албан бичгийг хүргүүлсэн. Сангийн яамны 2017.11.09-ний өдрийн 10/6363 тоот албан бичгээр тус төслийн зээл ашиглалтын хугацааг сунгах боломжгүй талаар мэдэгдсэн.	30
9.	Захиалагчийн төлөөлөгч томилох тухай 2015.10.12 №395	БТГ АТБХЗГ	2. Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийн үе шат бүрт захиалагчийг төлөөлөн хяналт, шаардлага тавьж ажиллахыг төлөөлөгч нарт даалгасугай.	Автотээвэр, Иргэний нисэхийн салбарын стандарт олон улсын стандарт нутагшуулахаар нийт 13 зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулагдсан бөгөөд тус гэрээт ажлуудад Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар захиалагчийн төлөөлөгчид	70

			/авто тээвэр, иргэний нисэхийн салбарт үндэсний стандарт боловсруулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил/	<p>томилогдсон бөгөөд гэрээт ажлын 9 нь стандарт боловсруулах, 4 нь судалгааны ажлын зөвлөх үйлчилгээний гэрээ болно. Гэрээт ажлуудын тайлан хугацаандаа ирж захиалагчийн төлөөлөгч нараас дүгнэлт гаргуулан СЭЗХ-т хүргүүлж, санхүүжилтийг шийдвэрлүүлж ажилласан. Зөвлөх үйлчилгээний гэрээт ажлаас стандарт боловсруулах 8 гэрээт ажил, судалгааны ажлын 4 гэрээт ажил хийгдэж дуусаад байна. Үлдсэн нэг ажил болох "Дэд бүтцийн сайдын "жишиг норм батлах тухай" 2004 оны 19 дүгээр тушаалын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах" ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний компанитай байгуулсан 2015 оны 216 дугаар гэрээг сунгах асуудлыг "Зам, тээврийн салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сан"-гийн Удирдах зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, норм, стандартын гэрээний хэрэгжилтийг хангах, батлуулах арга хэмжээ авсан. Зөвлөхийн ажлыг сунгаж, хяналт тавин ажиллаж байна. Нийт 13 ажлаас нэг ажил үлдсэн, хэрэгжилтийн шатанд байна.</p>	
10.	Захиалагчийн төлөөлөгч томилох тухай 2015.11.20 №449	БТГ ТЗДТБХЗГ	2.Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийн үе шат бүрт захиалагчийг төлөөлөн хяналт, шаардлага тавьж ажиллахыг төлөөлөгч нарт даалгасугай. /төмөр замын салбарт үндэсний стандарт боловсруулж, батлуулах зөвлөх үйлчилгээ/	<p>Төмөр замын салбарт олон улсын стандарт нутагшуулах 3 зөвлөх үйлчилгээний ажлын 2 ажил нь дууссан. Үлдсэн 1 ажлын гэрээг сунгасан. Сунгасан гэрээт ажлын хүрээнд боловсруулах шаардлагатай байгаа 4 стандартын нэг болох "ТВ 10504:2007–Төмөр замын бүтээн байгуулалтын төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, түүний зураг төслийн баримт бичгийг боловсруулахад тавих ерөнхий шаардлага" стандартыг 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс хойш 2 жилийн хугацаатайгаар хэрэглэхээр Стандарт, хэмжил зүйн газарт бүртгүүлсэн. Үлдсэн төмөр замын замын аж ахуйн чиглэлийн 3 стандартын төслийг боловсруулж, холбогдох байгууллагын санал авч тусган Төмөр зам, далай ашиглалт ба усан замын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон.</p>	70
11.	Зам, гүүрийн барилгын ажлын тухай 2016.02.16 №45	БТГ АЗБХЗГ	1.7. Ашиглалтад оруулах хугацаа дууссан боловч улсын комиссын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, техникийн шаардлага хангаагүй зөрчил, дутагдал ихээр илэрсэн зэрэг шалтгааны улмаас барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй болсон Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын	<p>Засварын ажлын тоо хэмжээ, шаардлагатай хөрөнгийн тооцоог хяналт тавин ажилласан "ЗТХТ" ТӨҮГ-аас гаргуулсан. Ажлын тоо хэмжээ, төсвийг хянасан бөгөөд холбогдох материалыг ТЗУХЭЗГ-ын хуулийн хэлтэст хүргүүлсэн. ТЗУХЭЗГ-аас шүүхэд нэхэмжлэлийг хүргүүлсэн. Сүхбаатар дүүргийн иргэний анхан шатны шүүхийн 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар зөрүүтэй байгаа нотлох баримтад үзлэг хийх</p>	70



			гүйцэтгэгч “Чайна Гео Инженеринг” ХХК-тай байгуулсан гэрээг цуцлах арга хэмжээг авч, эцсийн төлбөр тооцоог барагдуулах;	шаардлагатай гэж үзэн шүүх хуралдааныг 2017 оны 10 дугаар сарын 02-ны өдөр болгож хойшлуулсан. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017.10.13-ний өдрийн хуралдаанаар ЗТЯ-ын нэхэмжлэлтэй хариуцагч “Чайна Гео Инженеринг Корпораци” ХХК-д холбогдох 10,945,921,481.0 төгрөг гаргуулах, 3,641,936,199 төгрөг гаргуулах тухай сөрөг нэхэмжлэлтэй иргэний хэргийг гомдлыг үндэслэн хэлэлцэж, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 06 сарын 28-ны өдрийн 101/ШШ2017/02239 дугаар шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаагаад байна.	
12.	Ажлын хэсэг байгуулах тухай 2016.03.14 №84	ХШҮДАГ 2016.04.01	2. Хүлээлгэн өгөөгүй байгаа тоног төхөөрөмж, програм хангамжийг АТҮТ ТӨҮГ-т хүлээлгэн өгөхдөө хурлын протокол, акт зэрэг үйлдэж, 2016.04.01-ний дотор багтаан танилцуулахыг Ажлын хэсэг /П.Билгүүн/-т үүрэг болгосугай. /ЗТЯ, Болгар улсын "Контракс ЕАД" компанитай байгуулсан "Тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил" 45/А тоот гэрээ хэрэгжиж дууссантай холбогдуулан хүлээлгэн өгөөгүй байгаа тоног төхөөрөмж, програм хангамжийг АТҮТ ТӨҮГ-т хүлээлгэн өгөх ажлын хэсэг/ нбд-Н.Уугандулам	Уг ажлын хэсэг 2016.03.14-ний өдөр “АТҮТ” ТӨҮГ-ын захирлын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 9 гишүүнтэй хурал хийж, дараах шийдэлд хүрсэн. Үүнд: 1. ЗТЯ-ны ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн Э.Батсүх “АТҮТ” ТӨҮГ-т Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээлэл болон Авто үйлчилгээний програмын гарын авлага өгөх; 2. “АТҮТ” ТӨҮГ-ын дэд захирал Т.Баясгалан ЗТЯ-нд Тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан болон Авто үйлчилгээний програм хангамжтай ажиллах сургалт зохион байгуулах өдрийн хуваарь болон Тээврийн хэрэгслийн бүртгэлийн сан /VRS/-тай холбоотой санал бүхий албан бичиг ирүүлэх. “АТҮТ” ТӨҮГ-ын холбогдох албан тушаалтан нарт 2016 оны 5 дугаар сард програм хангамжтай ажиллах сургалтыг зохион байгуулсан. Мөн Зам, тээврийн сайдын 2016.04.12-ны өдрийн 90 дүгээр тушаалаар “Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам” батлагдсантай холбогдуулан “Контракс ЕАД” компанийн нийлүүлсэн Авто үйлчилгээний нэгдсэн сан, програм хангамжинд өөрчлөлт хийлгэх шаардлагатай болсон тул “Контракс ЕАД” компанид өөрчлөлт хийлгүүлэх хүсэлтээ 2016.06.23-ны өдрийн 07/2777 тоот албан бичгээр хүргүүлсэн. ТНБД-ын 2017.05.12-ны өдрийн 139 дүгээр тушаалаар байгуулсан Ажлын хэсэг ажиллаж "Тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил"-ын 45/А тоот гэрээний хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүд эвхийн ажиллагаатай эсэхийг шалгах тооллого хийж, тайланг	30



				Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Э.Идэрцогд 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 03/2892 тоот албан бичгээр хүргүүлсэн.	
13.	Үнэлгээний хороо байгуулах тухай 2016.11.18 №171	төслийн нэгж	3. Тендер шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг ҮХ-ний нбд /Г.Эрхэмбаяр/-д үүрэг болгосугай. /Логистикийн төвийн барилга байгууламжийн гүүрэн краны нийлүүлэлт, угсралт, туршилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах/	Тендер шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлсэн, архивын эрхлэгчид хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.	70
14.	Ажлын хэсэг байгуулах тухай 2017.02.06 №27	АЗБХЗГ 2017.02.20	2. Ажлын хэсэг нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу лабораторийн тоног төхөөрмжийг хүлээн авч яамны удирдлагад 2017.02.20-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн дарга /Д.Доржханд/-д даалгасугай. /олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөлд хэрэглэгдэж байсан лабораторийн тоног төхөөрмжийг хүлээн авах ажлын хэсэг/ нбд-Б.Дархандарьяа	Лабораторийн тоног төхөөрмжийг хүлээн авах ажлын хэсэг 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл дээр очиж ажилласан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нэгжээс уг тоног төхөөрмжийг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүлээлгэн өгөх тухай ойлголтгүй, хэн хүлээлгэж өгөх нь тодорхой бус байсан учир 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 03/608 дугаартай албан бичгийг ИНЕГ-т хүргүүлсэн. ИНЕГ-аас “Самсунг Си энд Ти” корпорацийн 100 хувийн хөрөнгө оруулалттай “Эс Си Ти И Си Эм” ХХК-ийн Монгол Улсад хэрэгжүүлж буй өөр төсөлтэй холбогдуулж үүсгэсэн хэргийн хүрээнд хуулийн байгууллагаас төслийн лабораторийн барилга, тоног төхөөрмжийг битүүжилсэн учир хуулийн байгууллагаас хариу ирмэгц хөрөнгө хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулах тухай 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/1507 дугаартай албан бичгийг ирүүлээд байна. Шүүхийн маргаантай байгаа учир хүлээн авах ажлын хэсэг ажиллах боломжгүй болсон.	
15.	Авто зам, гүүрийн барилгын ажлын тухай 2017.02.08 №36	БТГ АЗБХЗГ	1.6. Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Үүрийн голын 350 у/м төмөрбетон гүүрийн барилга угсралтын ажилд гарсан технологийн алдаанаас үүсэх эрсдэлийг хэрхэн арилгах талаар хөндлөнгийн шинжээч томилон ажиллуулах, шинжээчийн дүгнэлтийг үндэслэн Улсын комисс ажиллах асуудлыг шийдвэрлэх;	Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Үүрийн голын 350 у/м төмөр бетон гүүрийн барилга угсралтын ажил бүрэн ажил дууссан. Энэхүү гүүрийг цаашид ашиглах боломжтой эсэх талаар улсын байцаагчийн дүгнэлт гаргуулахаар албан тоот хүргүүлсэн боловч захиалагч, гүйцэтгэгч болон хяналтын байгууллага хамтран гүүрийн зураг төсөл болон барилга угсралтын ажилд хөндлөнгийн мэргэжлийн зөвлөх байгууллагаар туршилт, шинжилгээний ажлыг гүйцэтгүүлэх шаардлагатай байна гэсэн хариуг МХЕГ-аас өгсөн. ШУТИС-ын Оношлогоо, зураг төсөл, судалгааны төвөөс 2017 оны 09 дугаар сарын 23-нд хөндлөнгийн шинжээчдийн баг ажиллаж гүүрэнд статик, динамик ачааллын туршилт шинжилгээг газар дээр нь хийсэн бөгөөд дүгнэлт гарган ирүүлсэн. Энэхүү дүгнэлтийг судалж, зураг зохиогч "Эн Би Си	70



				Си" ХХК-д санал ирүүлэх талаар 2017.11.27-ны өдрийн 10/5205 тоот албан бичгээр хүргүүлээд байна. Дүгнэлтэд үндэслэн гүүрийг ашиглах боломжтой эсэх, улсын ашиглалтад оруулах асуудлыг шийдвэрлэх болно.	
16.	Ажлын хэсэг байгуулах тухай 2017.02.15 №45	АТБХЗГ	3. Удирдамжийн дагуу ажил, үйлчилгээг шуурхай зохион байгуулахыг Ажлын хэсэг /Г.Гантулга/-д үүрэг болгосугай. /УБ хотын олон улсын нисэх онгоцны шинэ нисэх буудал чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг нээх бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах/ нбд- П.Наранцэцэг	Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий "Ажлын хэсэг" нь удирдамжийн дагуу 9 заалт бүхий хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажилласан.Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын захиргааны өмнөх албаны удирдлагуудтай уулзаж, шинэ буудлын үйлчилгээний танхим болон гадна талбайн ашиглалтын төлөвлөлт, зохион байгуулалттай танилцсан. Нийтийн тээвэр болон жуулчин тээврийн автобус, такси үйлчилгээний тээврийн хэрэгслийн зогсоолын байршил, тээврийн мэдээлэл-нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх танхимын байршлыг урьдчилан тохиров. Олон улсын нисэх онгоцны төв буудлын үйлчилгээний жишигт хүргэх, иргэд, зорчигчдын эрэлт, хэрэгцээ шаардлагад нийцүүлж нийтийн тээвэр, тээврийн мэдээлэл – нэг цэгийн үйлчилгээ, зорчигчийн тээш урьдчилан хүлээн авах буюу хүргэлт, автомашины төлбөртэй зогсоол, түрээсийн автомашин эзэмшүүлэх үйлчилгээ гэх мэт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн шинэ үйлчилгээг бий болгох зорилгоор "Төсөл сонгон шалгаруулах ажлын даалгавар"-ын төсөлд тусгасан. Мөн "Төсөл сонгон шалгаруулалт явуулах удирдамж"-ийн төслийг боловсруулсан. Нисэх онгоцны шинэ буудлаас нийслэл хотын хооронд нийтийн тээвэрлэлтийн 6 чиглэл нээхээр урьдчилсан тооцоо хийж, "хот орчим"-ын тээврийн төрөлд хамруулах боломжтой гэж үзлээ. Энэхүү асуудлаар Нийслэлийн Засаг даргын орлогч П.Баярхүүтэй уулзаж, тээвэрлэлтийг Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн тээврийн газарт хариуцуулах нь зүйтэй гэж үзэв. Ажлын хэсэг нь удирдамжийн дагуу үйлчилгээний бэлтгэлийг хангах ажлыг 2017 оны 05 дугаар сарын 01-ний дотор дуусгавар болгон, ажлын үр дүнг танилцуулах үүрэгтэй. Гэвч шинэ буудлын зам, барилгын ажил бүрэн дуусаагүй, 2018 оны 3 дугаар улирал хүртэлх хугацаагаар сунгагдснаар нийтийн тээврийн үйлчилгээг нээх, тээвэрлэгч аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, авто зогсоолын байршилд тэмдэг, тэмдэглэгээг хийх, тохижуулах, мэдээллийн дэлгэц	70



				ажиллуулах, олон нийтэд мэдээлэл хүргэх зэрэг ажлуудыг хойшлуулав. Ажлын хэсэг холбогдох асуудлаар шийдвэр гаргуулахаар Сайдын Зөвлөлийн хуралд оруулахаар ажиллаж байна.	
17.	Ажил хариуцуулж, хэрэгжүүлэх тухай 2017.03.06 №59	Газар, хэлтсүүд	2. Жагсаалтад тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнаж ажиллахыг холбогдох газар хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай. /"МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд ЗТХ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хариуцан ажиллах жагсаалт/	Засгийн газрын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2016 оны жилийн эцэс, 2017 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг тогтоосон аргачлал, зааврын дагуу хийж, тайланг удирдлагад танилцуулж, албажуулан ЗГХЭГ-т хүргүүлсэн. 2017 оны жилийн эцсийн байдлаар ЗТХЯ-ны хариуцан хэрэгжүүлэх 95 арга хэмжээний биелэлт 79.3%-тай байна.	70
18.	Ажлын хэсэг томилго тухай 2017.05.22 №145	ТЗДТБХЗГ 2017.06.15	3. Ажлын хэсгийн дүгнэлтийг 2017.06.15-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын ахлах мэргэжилтэн /Б.Лхагвасүрэн/-д үүрэг болгосугай. /УБТЗ ХНН-ний Давааны зөрлөгөөс Амгалан өртөө хооронд төмөр зам доогуур нийт 28 байршилд нүхэн гарц гаргах, авто замтай 2 түвшинд огтлолцох нөхцлийг судлан түүний түвшин, байршлыг тодорхойлох, дүгнэлт гаргах/ нбд-Т.Энхбаатар	ЗТХЯ, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, "УБТЗ" ХНН, Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2017 оны 05 дугаар сарын 29, 30-ны өдөр "УБТЗ" ХНН-ийн Давааны зөрлөгөөс Амгалан өртөө хооронд төмөр зам доогуур нүхэн гарц гаргах, авто замтай 2 түвшинд огтлолцох техникийн нөхцлийг газар дээр судлан үзэж ажилласан. "УБТЗ" ХНН-ээс ажлын хэсэгт оролцсон гишүүд төлөвлөж буй зарим огтлолцох газруудын байршлыг "УБТЗ" ХНН-ийн Замын даргад танилцуулан санал өгнө гэсэнтэй холбоотойгоор ажлын хэсгийн дүгнэлт эцэслэн гараагүй байна. Огтлолцлын цэг, техникийн нөхцлийн талаар "УБТЗ" ХНН нь санал ирүүлэхгүй байгаа учраас дүгнэлт гаргах асуудал хойшлогдоод байгаа.	70
19.	Ажлын хэсэг байгуулах тухай 2017.06.14 №176	АЗБХЗГ 2017.06.30	2. Гэрээг дуусгавар болгож, эцсийн тооцоо хийх ажлыг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хийж, үр дүн, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан 2017.06.30-ны дотор танилцуулахыг Ажлын хэсэг /Д.Доржханд/-д даалгасугай. /Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто зам /Багц-4/-ын гүйцэтгэгч Чайна Хуаши Энтерпрайзес Лимитед компанитай байгуулсан гэрээг дуусгавар болгож эцсийн тооцоо хийх/ нбд-Л.Баянзул	"Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто зам /Багц-4/-ын гүйцэтгэгч Чайна Хуаши Энтерпрайзес Лимитед компанитай байгуулсан гэрээг 2017.06.30-ны өдөр цуцалсан. Гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэлийг хянан баталгаажуулахаар ХОУХ-т хүргүүлсэн. БТГ-ын ХОУХ-ийн зүгээс эцсийн төлбөр тооцоог хийнэ.	70
20.	Хуулийн хэрэгжилтийг хангах тухай 2017.06.23	АЗБХЗГ БТГ ТЗУГ ЗТХТ	3. Журмын төслүүдийг 2017 оны 10 сард эцэслэн боловсруулж, батлуулах арга хэмжээ авахыг ажлын хэсгийн дарга нарт үүрэг болгосугай. /Авто замын тухай хуулийн	Төрийн нарийн бичгийн даргын 2017.06.23-ны өдрийн 191 дугаар тушаалаар Авто замын хуультай холбогдуулан 16 журам боловсруулах ажлын хэсгүүд байгуулагдсан. Бүх журмын төсөл	70



	№191 /2017.10.30-ны №352 тушаалаар өөрчлөлт оруулсан/	2017.10.31	шинэчилсэн найруулга 2017.07.01-ний өдрөөс дагаж мөрдөх болсонтой холбогдуулан уг хуульд заасан журмын төсөл боловсруулах ажлын хэсгүүд-11/ дарга-Ж.Сэрээтэр, Р.Буд, Д.Цэцэгмаа, Б.Минжбадам, Х.Оргил-Эрдэнэ, Д.Загдраднаа нбд-Ө.Одгэрэл, Ц.Эрдэнэ-очир, Б.Гийвийшинэн, Д.Энхтуяа, Б.Ууганбаяр, С.Мөнхбат, Н.Сугаржав, Ц.Хосгэрэл, Б.Дархандарьяа, Ч.Сугармаа, Л.Баянзул	боловсруулагдаж дууссан бөгөөд “Захиргааны ерөнхий хууль”-ийн 62.1-т заасны дагуу олон нийтээр хэлэлцүүлж байна.	
21.	Үнэлгээний хороо байгуулах тухай 2017.07.05 №207 /2017.09.13-ны №304, 2017.11.02-ны №361 тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан/	ТЗДТБХЗГ Төслийн нэгж	2. Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Үнэлгээний хорооны дарга /Б.Артур/-д, холбогдох материалыг архивын нэгж болгон бүрдүүлж, архивт хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нбд /Г.Эрхэмбаяр/-д тус тус даалгасугай. /Замын-Үүдийн ложистикийн төвийн төмөр замын дохиолол, холбооны зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралт, суурилуулалт, засвар үйлчилгээний ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах/	Төмөр замын дохиолол холбооны зураг төсөл болон угсралтын ажлыг цогцоор нь гүйцэтгэх аж ахуйн нэгжийг шалгаруулах тендерийг 2017 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр өдөр тутмын хэвлэл болон АХБ, ЗТХЯ-ны цахим хуудсуудад байршуулан зарласан. Тендерийн баримт бичгийг худалдан авах үед төлбөр төлөхдөө буруу данс руу хийгдсэнээс шалтгаалан Сэймэнс компани тендерийн хугацааг сунгах хүсэлтийг Азийн хөгжлийн банкинд гаргасанд үндэслэн тендерийг нээх хугацааг 2017 оны 11 дүгээр сарын 03-нд байсныг 11 дүгээр сарын 20-ны өдөр болгон хойшлуулсан. Тендерийн нээлтэнд 5 байгууллага хятад улсын 3, энэтхэг улсын 1, Сэймэнс оролцсон. 2017 оны 12 сарын 06-ны байдлаар 5 байгууллагын тендерт үнэлгээ хийгдэж, үнэлгээний хороо шийдвэр гаргасан бөгөөд Азийн хөгжлийн банк-д танилцуулахаар материал англи хэл рүү орчуулагдаж байна.	70
22.	Үнэлгээний хороо байгуулах тухай 2017.10.02 №327	АЗБХЗГ	2. Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Үнэлгээний хорооны дарга /Д.Доржханд/-д, холбогдох материалыг архивын нэгж болгон бүрдүүлж архивт хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нбд /Б.Оюундэлгэр/-д даалгасугай. /"Баруун бүсийн авто замын коридор хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Төсөл-1"-ийн хэмнэгдсэн хөрөнгөөр өвлийн засвар, арчлалтын машин худалдан авах/	Үнэлгээний хороо уг ажлын тендерийн баримт бичгийг АХБ-ны худалдан авах ажиллагааны журмын дагуу боловсруулсан бөгөөд үнийн саналыг авахаар 3 аж ахуйн нэгж байгууллагад урилга хүргүүлсэн.	30